



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар A/39

Улаанбаатар хот

Эрчим хүчний яамны дэргэдэх Ёс зүйн
дэд хороо байгуулах гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоол, Яамны нийт албан хаагчдын санал асуулгын дүнг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн тоог 7 байхаар тогтоож, дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Д.Даваасүрэн- Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч
- Л.Мэнхцог- Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч
- Б.Нармандах- Гэрээ, эрх зүйн газрын ахлах шинжээч
- Б.Ариундэлгэр- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч
- П.Жаргалсайхан- Санхүү хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч
- Б.Пунцагбалжир- Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн
- Б.Оюунгэрэл- Төрийн үйлчилгээний албан хаагч

2. Ёс зүйн дэд хороог хороог холбогдох хууль тогтоомжийн хүрээнд удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Ж.Хичээнгүй)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны "Эрчим хүчний яамны дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг шинэчлэн томилох тухай" А/56 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Н.ТАВИНБЭХ

170600060358